

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2009 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2009.11.23

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

Тайлант улиралд Хорооны тогтоолоор 3 ББСБ-д гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, 4 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 172 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Тайлант улирлаар | Өмнөх оны мөн үеэр |
|----------|---|------------------|--------------------|
| 1 | ББСБ-ын тоо | 172 | 131 |
| 2 | Хувь нийлүүлэгчдийн тоо | 432 | 435 |
| 3 | Ажиллагсадын тоо | 759 | 641 |
| 4 | Салбар нэгжийн тоо | 57 | 64 |
| 5 | Харилцагчдын тоо /мянган төгрөгөөр/ | 84.5 | 74.8 |
| 6 | Нийт актив /мянган төгрөгөөр/ | 89,320,627.4 | 76,402,128.1 |
| | <i>Банкны салбарт эзлэх хувь</i> | 2.2% | 2.0% |
| 7 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ | 49,954,945.9 | 45,033,494.7 |
| | <i>Банкны салбарт эзлэх хувь</i> | 1.9% | 1.2% |
| 8 | Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/ | 68,888,094.1 | 50,708,717.8 |
| | <i>Банкны салбарт эзлэх хувь</i> | 27.6% | 11.1% |
| 9 | Нийт дүрмийн сан буюу хувьцаат капитал /мянган төгрөгөөр/ | 61,421,490.8 | 43,605,767.9 |
| | <i>Банкны салбарт эзлэх хувь</i> | 25.5% | 18.9% |
| 10 | Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/ | 3,225,052.3 | 2,690,240.2 |
| 11 | Нийт орлого /мянган төгрөгөөр/ | 19,596,686.5 | 12,944,438.8 |
| 12 | Нийт зардал /мянган төгрөгөөр/ | 15,844,583.4 | 10,169,441.6 |
| 13 | Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/ | 3,752,103.1 | 2,774,997.1 |
| 14 | Активын өгөөж /ROA/ | 5.1 | 4.8 % |
| 15 | Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ | 6.0 | 6.7 % |
| 1 | Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо | 8 | 11 |
| | <i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i> | 4.6% | 8.4% |
| A | Нийт актив /мянган төгрөгөөр/ | 12,694,871.0 | 14,825,052.9 |
| | <i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i> | 14.2% | 19.4% |
| B | Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ | 9,250,929.8 | 6,200,223.5 |
| | <i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 18.5% | 13.8% |
| B | Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/ | 6,337,361.8 | 8,519,061.8 |
| | <i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i> | 9.2% | 16.8% |
| Г | Нийт дүрмийн сан буюу хувьцаат капитал /мянган төгрөгөөр/ | 6,721,032.5 | 9,192,366.6 |
| | <i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i> | 10.9% | 21.1% |
| 2 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо | 26 | 22 |
| | <i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i> | 15.1% | 16.8% |
| A | Нийт актив /мянган төгрөгөөр/ | 3,018,985.4 | 2,069,944.1 |
| | <i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i> | 3.4% | 2.7% |
| B | Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ | 2,260,602.5 | 1,693,306.1 |
| | <i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 4.5% | 3.8% |
| B | Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/ | 2,713,231.2 | 1,659,090.7 |
| | <i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i> | 3.9% | 3.3% |
| Г | Нийт дүрмийн сан буюу хувьцаат капитал /мянган | 2,393,459.2 | 1,369,359.1 |

| | | | |
|----------|--|-------------|-----------|
| | <i>төгрөгөөр/</i> | | |
| | <i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i> | 3.9% | 3.1% |
| 3 | Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо | 47 | 1 |
| | <i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i> | 27.3% | 0.6% |
| A | Нийт актив /мянган төгрөгөөр/ | 5,724,465.1 | 510,984.2 |
| | <i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i> | 6.4% | 0.6% |
| B | Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/ | 5,699,789.3 | 510,914.7 |
| | <i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i> | 8.3% | 0.8% |
| B | Нийт дүрмийн сан буюу хувьцаат капитал /мянган төгрөгөөр/ | 5,046,367.1 | 400,000.0 |
| | <i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i> | 8.2% | 0.7% |

Нийт ББСБ-ын 11.6 хувь буюу 20 ББСБ-д салбарын нийт активын 53,8 хувь, нийт зээлийн багцын 62,9 хувь, нийт эзэмшигчдийн өмчийн 45.2 хувь тус тус ногдож байгаа ба нийт ББСБ-ын 5.8 хувь буюу 10 ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээний өглөгийн хэмжээ нийт өр төлбөрийн 15.8 хувь, 8.1 хувь буюу 14 ББСБ-ын банк, санхүүгийн байгууллагад төлөх нийт өглөгийн хэмжээ нийт өр төлбөрийн 43.5 хувь, 9.9 хувь буюу 17 ББСБ-ын төслийн зээлийн санхүүжилтийн нийт өглөгийн хэмжээ нийт өр төлбөрийн 15.1 хувийг тус тус эзэлж байна.

ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа, үйлчилгээг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан төрлөөр нь ангилж үзэхэд дараах байдалтай байна.

| № | Үйл ажиллагааны төрөл | Тоо |
|-----|--|-----|
| 1. | Зээл | 127 |
| 2. | Факторингийн үйлчилгээ | 5 |
| 3. | Санхүүгийн түрээс | 5 |
| 4. | Төлбөрийн баталгаа гаргах | 5 |
| 5. | Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах | 0 |
| 6. | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 5 |
| 7. | Гадаад валютын арилжаа | 102 |
| 8. | Итгэлцлийн үйлчилгээ | 12 |
| 9. | Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 3 |
| 10. | Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх | 9 |
| 11. | Хөрөнгө оруулалтын үйлчилгээ | 1 |

ХОЁР. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант улирлын нийт орлого өмнөх оны мөн үеэс 46.5 хувиар өссөн ба дараах бүтэцтэй байна. Үүнд:

| № | Үзүүлэлтүүд | Тайлант үе | | Өмнөх оны мөн үе | | Өөрчлөлт | |
|--------------------|-----------------------------------|---------------------|--------------|---------------------|--------------|--------------------|-------------|
| | | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| 1 | Хүүгийн орлого | 10,336,174.2 | 52.7 | 6,855,222.8 | 51.2 | 3,480,951.4 | 50.8 |
| 2 | Хүүгийн бус орлого | 8,973,480.4 | 45.8 | 6,292,710.5 | 47.0 | 2,680,769.9 | 42.6 |
| 3 | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 282,157.2 | 1.4 | 224,292.8 | 1.7 | 57,864.4 | 25.8 |
| 4 | Ердийн бус орлого | 4,874.7 | 0.0 | 7,740.2 | 0.1 | -2,865.5 | -37.0 |
| Нийт орлого | | 19,596,686.5 | 100.0 | 13,379,966.3 | 100.0 | 6,216,720.2 | 46.5 |

Нийт орлогын өсөлтийн голлох үзүүлэлтүүд нь үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн болон хүүгийн бус орлого /үүнээс: гадаад валютын арилжааны орлого, итгэлцлийн үйлчилгээний орлого, мөнгөн гуйвуулгын орлого, үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого/ байна.

Тайлант хугацаануудад хүүгийн болон хүүгийн бус орлогын нийт орлогод эзлэх хувь хэмжээнд төдийлэн өөрчлөлт ороогүй байна.

Нийт зардал дараах бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| № | Үзүүлэлтүүд | Тайлант үе | | Өмнөх оны мөн үе | | Өөрчлөлт | |
|--------------------|-----------------------------------|---------------------|--------------|---------------------|--------------|--------------------|-------------|
| | | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| 1 | Хүүгийн зардал | 1,014,516.7 | 6.4 | 830,510.4 | 7.6 | 184,006.3 | 22.2 |
| 2 | Хүүгийн бус зардал | 12,374,578.5 | 78.1 | 8,301,072.2 | 76.3 | 4,073,506.3 | 49.1 |
| 3 | Болзошгүй эрсдэлийн зардал | 1,782,565.1 | 11.3 | 1,302,073.0 | 12.0 | 480,492.1 | 36.9 |
| 4 | Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 180,224.1 | 1.1 | 119,617.4 | 1.1 | 60,606.7 | 50.7 |
| 5 | Ердийн бус зардал | 9,518.2 | 0.1 | 6,586.1 | 0.1 | 2,932.1 | 44.5 |
| 6 | Орлогын татварын зардал | 483,180.8 | 3.0 | 319,696.3 | 2.9 | 163,484.5 | 51.1 |
| Нийт зардал | | 15,844,583.4 | 100.0 | 10,879,555.5 | 100.0 | 4,965,027.9 | 45.6 |

Тайлант хугацааны нийт зардал өмнөх оны мөн үеэс 45.6 хувь өссөн ба үүнд гадаад валютын арилжааны зардал /хамгийн өндөр өсөлттэй/, хүүгийн зардал, болзошгүй эрсдэлийн зардал, үндсэн бус үйл ажиллагааны зардал, орлогын татварын зардлууд голлох хувийг эзэлж байна.

ББСБ-ууд тайлант хугацаанд нийт 3,752.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд 5.2 мянган төгрөгөөс 441.6 сая хүртэлх төгрөгийн цэвэр ашигтай ажилласан 121 ББСБ байгаа нь нийт ББСБ-ын 70.3 хувийг, 17.1 мянган төгрөгөөс 471.8 сая хүртэлх төгрөгийн алдагдалтай ажилласан 35 ББСБ байгаа нь нийт ББСБ-ын 20.3 хувийг тус тус эзэлж байна.

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Активын бүтэц, өөрчлөлт:

ББСБ-уудын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| Хөрөнгө | Тайлант үе | | Өмнөх оны мөн үе | | Өөрчлөлт | | |
|---------|---|--------------------------|---------------------|--------------|---------------------|--------------|---------------------|
| | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь | |
| | А | Эргэлтийн хөрөнгө | 85,125,841.5 | 95.3 | 71,655,909.7 | 93.8 | 13,469,931.8 |
| 1 | Мөнгөн хөрөнгө | 29,653,256.4 | 33.2 | 17,831,053.0 | 23.3 | 11,822,203.4 | 66.3 |
| 2 | Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/ | 3,176,964.2 | 3.6 | 97,737.3 | 0.1 | 3,079,226.9 | 3,150.5 |
| 3 | Нийт зээл /цэврээр/ | 46,697,900.6 | 52.3 | 43,484,867.6 | 56.9 | 3,213,033.0 | 7.4 |
| | (Зээлийн эрсдэлийн сан) | 3,257,045.3 | 3.6 | 1,548,627.1 | 2.0 | 1,708,418.2 | 110.3 |
| 4 | Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/ | 254,536.8 | 0.3 | 148,797.3 | 0.2 | 105,739.5 | 71.1 |
| | Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө | 260,230.8 | 0.3 | 109,604.5 | 0.1 | 150,626.3 | 137.4 |
| | (ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан) | 25,722.5 | 0.0 | 22,418.1 | 0.0 | 3,304.4 | 14.7 |
| | Өмчлөх бусад хөрөнгө | 20,028.5 | 0.0 | 61,610.9 | 0.1 | -41,582.4 | -67.5 |
| 5 | Бусад хөрөнгө | 5,343,183.5 | 6.0 | 10,090,007.0 | 13.2 | -4,746,823.5 | -33.4 |

| | | | | | | | |
|----------|---|---------------------|--------------|---------------------|--------------|---------------------|--------------|
| | Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 1,887,449.6 | 2.1 | 1,323,010.6 | 1.7 | 564,439.0 | 42.7 |
| | Нийт авлага /цэврээр/ | 2,667,840.2 | 3.0 | 2,752,328.5 | 3.6 | -84,488.3 | -3.1 |
| | (Авлагын эрсдэлийн сан) | 33,245.5 | 0.0 | 5,714.5 | 0.0 | 27,531.0 | 481.8 |
| | Бусад актив | 787,893.7 | 0.9 | 6,020,382.4 | 7.9 | -5,232,488.7 | -86.9 |
| Б | Эргэлтийн бус хөрөнгө | 4,194,785.9 | 4.7 | 4,746,218.3 | 6.2 | -551,432.4 | -11.6 |
| 6 | Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/ | 4,194,785.9 | 4.7 | 4,746,218.3 | 6.2 | -551,432.4 | -11.6 |
| | (Хуримтлагдсан элэгдэл) | 1,305,804.2 | 1.5 | 1,074,888.8 | 1.4 | 230,915.4 | 21.5 |
| | Нийт хөрөнгийн дүн | 89,320,627.4 | 100.0 | 76,402,128.1 | 100.0 | 12,918,499.3 | 16.9 |

Тайлант хугацаанд нийт эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт актив өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар өсч, нийт активын бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Түргэн борлогдох актив өмнөх оны мөн үеэс 66.3 хувиар өссөн нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлсэн, цэвэр зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс төдийлэн өсөөгүй, олгосон зээлийн багцын чанар муудсантай холбоотойгоор зээлийн эрсдэлийн сангийн нийт активт эзлэх хувийн жин 1.1 хувиар өссөн байна.

3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| № | Ангилал | Тайлант үе | | Өмнөх оны мөн үе | | Өөрчлөлт | |
|---|------------------------|---------------------|--------------|---------------------|--------------|--------------------|-------------|
| | | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| 1 | Хэвийн зээл | 42,116,130.3 | 84.3 | 41,430,629.8 | 92.0 | 685,500.5 | 1.7 |
| 2 | Хугацаа хэтэрсэн зээл | 2,896,667.9 | 5.8 | 1,606,144.0 | 3.6 | 1,290,523.9 | 80.3 |
| 3 | Чанаргүй зээл. Үүнээс: | 4,942,147.8 | 9.9 | 1,996,720.9 | 4.4 | 2,945,426.9 | 147.5 |
| | а/ Хэвийн бус | 1,533,045.6 | 3.1 | 732,386.2 | 1.6 | 800,659.4 | 109.3 |
| | б/ Эргэлзээтэй | 1,518,011.9 | 3.0 | 388,643.6 | 0.9 | 1,129,368.3 | 290.6 |
| | в/ Муу | 1,891,090.3 | 3.8 | 875,691.1 | 1.9 | 1,015,399.2 | 116.0 |
| | Нийт | 49,954,945.9 | 100.0 | 45,033,494.7 | 100.0 | 4,921,451.2 | 10.9 |

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-уудын тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

| Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч | | Тайлант үе | | Өмнөх оны мөн үе | | Өөрчлөлт | |
|-------------------------------|--|---------------------|-------------|---------------------|-------------|---------------------|--------------|
| | | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| А | Өр төлбөр | 16,269,217.3 | 18.2 | 21,389,689.6 | 28.0 | -5,120,472.3 | -23.9 |
| 1 | Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 3,225,052.3 | 3.6 | 2,690,240.2 | 3.5 | 534,812.1 | 19.9 |
| 2 | Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг | 8,890,588.3 | 10.0 | 9,697,868.3 | 12.7 | -807,280.0 | -8.3 |
| 3 | Бусад эх үүсвэр | 1,072,896.2 | 1.2 | 2,642,458.5 | 3.5 | -1,569,562.3 | -59.4 |
| 4 | Төслийн зээлийн санхүүжилт | 3,080,680.5 | 3.4 | 6,359,122.5 | 8.3 | -3,278,442.0 | -51.6 |
| | Бусад өр төлбөр | 4,163,316.0 | 4.7 | 4,303,720.7 | 5.6 | -140,404.7 | -3.3 |

| | | | | | | | |
|--|---|---------------------|--------------|---------------------|--------------|---------------------|--------------|
| 5 | Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 206,568.9 | 0.2 | 219,101.1 | 0.3 | -12,532.2 | -5.7 |
| 6 | Бусад пассив | 3,956,747.1 | 4.4 | 4,084,619.6 | 5.3 | -127,872.5 | -3.1 |
| Нийт өр төлбөр | | 20,432,533.3 | 22.9 | 25,693,410.3 | 33.6 | -5,260,877.0 | -20.5 |
| Б | Эзэмшигчдийн өмч | 68,888,094.1 | 77.1 | 50,708,717.8 | 66.4 | 18,179,376.3 | 35.9 |
| 1 | Ердийн хувьцаа | 61,379,990.5 | 68.7 | 43,549,462.6 | 57.0 | 17,830,527.9 | 40.9 |
| 2 | Давуу эрхтэй хувьцаа | 41,500.4 | 0.0 | 56,305.3 | 0.1 | -14,804.9 | -26.3 |
| 3 | Бусад өмч | 510,322.1 | 0.6 | 734,815.2 | 1.0 | -224,493.1 | -30.6 |
| 4 | Сангууд | 1,136,877.4 | 1.3 | 1,089,223.6 | 1.4 | 47,653.8 | 4.4 |
| 5 | Тухайн үеийн ашиг/алдагдал | 3,752,103.1 | 4.2 | 2,774,997.1 | 3.6 | 977,106.0 | 35.2 |
| 6 | Хуримтлагдсан ашиг/алдагдал | 1,269,162.8 | 1.4 | 2,090,681.4 | 2.7 | -821,518.6 | -39.3 |
| 7 | Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/ | 798,137.9 | 0.9 | 413,232.6 | 0.5 | 384,905.3 | 93.1 |
| Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн | | 89,320,627.4 | 100.0 | 76,402,128.1 | 100.0 | 12,918,499.3 | 16.9 |

ББСБ-уудын өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмч 1.4 дахин, итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.2 дахин өссөнтэй холбоотойгоор нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 1.2 дахин өсчээ.

Санхүүгийн үзүүлэлтүүдийн бүтцийн хувьд нийт пассивт эзлэх хувь хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт өр төлбөр 9.8 хувиар буурсан /*үүнээс: нийт банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 2.7 хувиар, бусад эх үүсвэр 2.3 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 4.9 хувиар тус тус буурсан*/, нийт эзэмшигчдийн өмч 10.7 хувиар өссөн /*үүнээс: дүрмийн сан 11.6, тайлант үеийн ашиг алдагдал 0.6, хоёрдогч өглөг 0.4 хувиар тус тус өссөн бол, бусад өмч 0.4, сан 0.1, хуримтлагдсан ашиг 1.3 хувиар тус тус буурсан*/ байна. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэр буурч, өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн байна.

Хорооны 2009 оны “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169 дүгээр тогтоолд заасан дүрмийн сангийн байвал зохих доод хэмжээнд хүргээгүй нийт 62 ББСБ байгаагаас орон нутагт 8, Улаанбаатар хотод 54 ББСБ байна.

ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн хувьд Хорооны 2008 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүдийг хангаж ажилласан байна.

Харин Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 459/207 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2009 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 125/50 дугаар хамтарсан тушаалаар баталсан өөрчлөлтийн дагуу активын эрсдэлийн санг 3,229.0 сая төгрөгөөр байгуулбал зохихоос 87.4 сая төгрөгөөр илүү буюу нийт 3,316.4 сая төгрөгөөр байгуулсан байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО